# “ХАС МЕТАЛЛ” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ “ӨЛЗИЙТ-УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРД АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-021469



**2024 он**

# АГУУЛГА

**АГУУЛГА** ........ **1**
**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ** ........ **2**
**ЗУРГИЙН ЖАГСААЛТ** ........ **2**
**1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ** ........ **3**
1.1. Байгууллагын мэдээлэл ........ 3
1.2. Төслийн танилцуулга мэдээлэл ........ 3
1.2.1. Талбайн байршил ........ 3
1.2.2. Ордын нөөц ........ 5
1.3. 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл ........ 6
**2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ **8**
2.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт ........ 9
1.1. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт ........ 11
1.2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт ........ 15
**2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ **16**
**3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ **17**
3.1. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажил ........ 17
**4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ **20**
**5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ **21**
**6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ **22**
**7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ **24**
**8. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ** ........ **26**
**ДҮГНЭЛТ** ........ **30**

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэг ..... 5
Хүснэгт 2. Үйлдвэрийн нөөц ..... 6
Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 8
Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгааллын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ ..... 17
Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 22
Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт ..... 24
Хүснэгт 7. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ..... 26
Хүснэгт 8. Даланжаргалан суманд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд ..... 26

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Талбайн байршлын зураг ..... 3
Зураг 2. Уурхайн хотхон, оффисын талбай ..... 4
Зураг 3. Олборлолт, баяжуулалтын талбай ..... 4
Зураг 4. Уурхайн ухаш, баяжуулалтын талбай ..... 5
Зураг 5. Уурхайн сүүлийн жилийн байдлаарх ашиглалтын зураг ..... 6
Зураг 6. 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний план зураг ..... 7
Зураг 7. Тоосжилт бууруулах усалгаа хийгдэж буй байдал ..... 9
Зураг 8. Тээврийн замыг хатуу хучилттай болгохоор шороо асгаж буй байдал ..... 9
Зураг 9. Тээврийн замыг хатуу хучилттай болгохоор шороо дэвсэж буй байдал ..... 10
Зураг 10. Төслийн талбайд тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан байдал ..... 11
Зураг 11. Ус ашиглах гэрээ ..... 12
Зураг 12. 2024 оны ус ашиглуулах дүгнэлт ..... 13
Зураг 13. Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ ..... 14
Зураг 14. Хаягдал усны дүгнэлт ..... 14
Зураг 15. Ус ашигласны төлбөр төлсөн баримт ..... 15
Зураг 16. Засварын талбайг сайжруулсан байдал ..... 11
Зураг 17. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд төслийн талбайд тариалсан мод /5 сард/ ..... 17
Зураг 18. Мод суулгах ажлыг гүйцэтгэж буй байдал /10 сарын 20-нд/ ..... 19
Зураг 19. Галын аюулгүй байдлыг хангах самбар, галын аюулгүй байдлын хэрэгслүүд ..... 23
Зураг 20.Орон нутагтай байгуулсан хогны гэрээ ..... 24
Зураг 21. Хогны төлбөр төлсөн баримт ..... 25
Зураг 22. Байгаль орчны аудит хийлгэж баталгаажуулсан нүүр ..... 27
Зураг 23. Даланжаргалан сумын орох хаалгыг гүйцэтгэсэн байдал ..... 27
Зураг 24. Даланжаргалан сумын орох хаалгыг гүйцэтгэсэн ажлын төлбөрийн баримт ..... 28
Зураг 25. Малчдад 500 боодол өвс хүлээлгэн өгөхөөр бэлдэж буй байдал ..... 28
Зураг 26. Малчдад 2 тн тэжээл хүлээлгэн өгөхөөр бэлдэж буй байдал ..... 29
Зураг 27. Нөлөөллийн бүсийн айл өрхийн малчдын бууцыг түрж буй байдал ..... 29

# 1. ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

### *1.1. Байгууллагын мэдээлэл*

| | |
|---|---|
| Төсөл хэрэгжүүлэгч | “Хас металл” ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011511015 |
| Регистрийн дугаар | 5887917 |
| Хаяг | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Оранж плаза төвийн 502 тоот |
| Холбоо барих утас | 7011-1819, 8801-1111 |

### *1.2. Төслийн танилцуулга мэдээлэл*

#### *1.2.1. Талбайн байршил*

Өлзийт-Ухаа төмрийн хүдрийн орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 270 км, Даланжаргал сумын төвөөс зүүн хойш 40 км, Говь-сүмбэр аймгийн төв Чойр хотоос зүүн урагш 59 км, Өлзийт өртөөнөөс зүүн хойш 2 км-т, УБТЗ-ын 25-р зөрлөгөөс зүүн хойш 25 км зайд оршино.




*Зураг 1. Талбайн байршлын зураг*



*Зураг 2. Уурхайн хотхон, оффисын талбай*



*Зураг 3. Олборлолт, баяжуулалтын талбай*



*Зураг 4. Уурхайн ухаш, баяжуулалтын талбай*

*Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн эргэлтийн цэг*

| № | Газарзүйн солбицол | | Талбай, га |
|---|---|---|---|
| 1 | 108° 49' 17.62" E | 46° 1' 57.33" N | 123.84 |
| 2 | 108° 49' 17.62" E | 46° 1' 23.65" N | |
| 3 | 108° 48' 40.61" E | 46° 1' 23.65" N | |
| 4 | 108° 48' 40.61" E | 46° 1' 40.66" N | |
| 5 | 108° 48' 15.62" E | 46° 1' 40.66" N | |
| 6 | 108° 48' 15.62" E | 46° 1' 23.65" N | |
| 7 | 108° 48' 9.62" E | 46° 1' 23.65" N | |
| 8 | 108° 48' 9.62" E | 46° 1' 57.33" N | |

### *1.2.2. Ордын нөөц*

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Өлзийт-Ухаа төмрийн хүдрийн ордод 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан дахь төмрийн хүдрийн ордын геологийн нөөцийг бодитой (В) зэрэглэлээр хүдрээр 114 980.96 тн, металлаар 50 491.5 тн, боломжтой (С) зэрэглэлээр хүдрээр 135 173.08 тн, металлаар 59 133.3 тн, нийт бодитой болон боломжтой (В+С) зэрэглэлээр хүдрээр 250 154.04 тн, металлаар 109 624.8 тн-оор хүлээн авч бүртгэлжүүлсэн.

Үйлдвэрлэлийн нөөцийг уурхайн хүрээнд орж буй В+С зэргээр нийт 200.3 мян.тн хүдэрт тооцсон бөгөөд ашиглалтын явцад 3.19%-ийн хаягдал, 4.79%-ийн бохирдол үүсэхээр тооцоход үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ нийт 203.19 мян.тн байна.

*Хүснэгт 2. Үйлдвэрийн нөөц*

| Түвшин | Бодитой В нөөц, тн | Боломжтой С нөөц, тн | Бохирдлын хэмжээ, тн | Хаягдлын хэмжээ, тн | Үйлдвэрлэлийн нөөц, тн |
|---|---|---|---|---|---|
| **1295->1285** | - | 52 | 2 | 2 | 52.8 |
| **1285->1275** | 12,545 | 10,714 | 1,114 | 778 | 23,595.1 |
| **1275->1265** | 40,577 | 35,524 | 3,644 | 2,545 | 77,198.8 |
| **1265->1255** | 45,687 | 32,441 | 3,741 | 2,613 | 79,255.5 |
| **1255->1245** | 16,172 | 6,592 | 1,090 | 761 | 23,092.5 |
| Нийт | **114,981** | **85,323** | **9,591** | **6,700** | **203,194.7** |




*Зураг 5. Уурхайн сүүлийн жилийн байдлаарх ашиглалтын зураг*

### *1.3. 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл*

2024 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр уурхайн бэлтгэл ажил 2024 оны 03-р сарын 1-ээс эхлэх бөгөөд бэлтгэл ажлын хүрээнд техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, зарим шаардлагатай засвар үйлчилгээний ажлууд хийгдэхээр төлөвлөсөн.

Гэвч 2024 оны гүйцэтгэлээр 4 дүгээр сарын 01-нээс 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл үйл ажиллагаа явуулсан.

2024 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 163.32 мян.м3 хөрс хуулж, 50 мян.тн хүдэр олборлон баяжуулж, 27.57 мян.тн баяжмал борлуулахаар төлөвлөж байсан бөгөөд төлөвлөгөөний биелэлтээр нийт 30 мян.м$^3$ хөрс хуулж, 20 мян.тн хүдэр олборлосон.



*Зураг 6. 2024 оны уулын ажлын төлөвлөгөөний план зураг*

## 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ | Зардал /төг/ | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|
| Агаар орчин | Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдийг холбогдох стандарт шаардлагын дагуу үзлэгт хамруулах | ҮА-ны зардлаар | Төсөлд ашиглаж буй тээврийн хэрэгслүүдийг үзлэгт оношилгоонд хамруулав. |
| | Уурхайн талбайд тоосжилт дарах усалгааг тогтмол хийх | 7 000 000 | Зам талбайн усалгааны ажлыг тогтмол гүйцэтгэсэн. /Зураг 7/ |
| | Тээврийн хэрэгслээс гарах тоос шороог багасгах үүднээс хучилтгүй замын гадаргын шаардлагатай хэсгүүдийг хусах | | Тээврийн шороон замыг сайжруулахаар шороо асгаж, замыг сайжруулав. Цаашид хатуу хучилттай болгохоор ажлууд хийгдэж байгаа. /Зураг 8, 9/ |
| | Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлах | | Үйл ажиллагааны турш баримтлав. |
| | Тээвэрлэлтийн замд тэмдэг байршуулан олон салаа зам гарахаас сэргийлэх | 250 000 | Төслийн талбайд тэмдэг, тэмдэглэгээ байршуулав. /Зураг 10/ |
| Гадаргын болон газрын доорх ус | ШТМ тээвэрлэх машиныг зориулалтын талбайд байршуулан орчмыг хатуу хучилттай болгох | ҮА-ны зардлаар | Засварын талбайг сайжруулсан. /Зураг 11/ |
| | Ус ашиглалтын гэрээ байгуулж, төлбөр төлөх | ҮА-ны зардлаар | Ус ашиглах гэрээг 2024.09.20-ны өдөр сумын ЗД-тай байгуулсан. /Зураг 12-16/ |
| Хөрсөн бүрхэвч | Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулах | - | Хог хаядлын гэрээг 2024.03.19-ны өдөр сумын ЗД-тай байгуулсан. /Зураг 22/ |
| | Олборлолтын ажил, овоолго, тээвэрлэлтийн үйл ажиллагаанаас талбайн хөрсний эвдрэлийг аль болох бага байлгахад чиглэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтоогдсон ажлын зурваст байлгах | - | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтоогдсон ажлын зурваст төслийн үйл ажиллагааны турш явуулав |
| **Нийт** | | 7 250 000 | |

### *2.1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт*

Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүдэд Монгол Улсад мөрдөгдөж буй утааны ба бохирдлын стандартууд болон олон улсын холбогдох стандартуудын шаардлагын дагуу үзлэгт хамруулсан.



*Зураг 7. Тоосжилт бууруулах усалгаа хийгдэж буй байдал*

Уурхайн талбайгаас засмал зам хүртэлх 1км замыг сайжруулж хатуу хучилттай болгохоор ээлж дараатай ажлуудыг гүйцэтгэсэн.



*Зураг 8. Тээврийн замыг хатуу  хучилттай болгохоор шороо асгаж буй байдал*




*Зураг 9. Тээврийн замыг хатуу  хучилттай болгохоор шороо дэвсэж буй байдал*









*Зураг 10. Төслийн талбайд тэмдэг, тэмдэглэгээ байршуулсан байдал*

### *1.1. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт*




*Зураг 11. Засварын талбайг сайжруулсан байдал*



**Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс**

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл /тухайлбал: газар хөдлөлт , үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт/-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /нөхөн төлбөр, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**Ус ашиглуулагчийг төлөөлж :**

Даланжаргалан сумын Байгаль орчны бодлогийн мэргэжилтэн

С.Дандарбаатар

Утас: 95018801

**Ус бохирдуулагчийг төлөөлж :**

"Хас метал"ХХК геологи

Н.Дамдинжав

Утас: 88021017



*Зураг 14. Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ*



**УМАРД ГОВИЙН ГҮВЭЭТ-ХАЛХЫН ДУНДАД ТАЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**
**ХАЯГДАЛ УСНЫ ДҮГНЭЛТ**

2024 оны 10 дугаар 14-ны өдөр Дугаар: **39** Говьсүмбэр Сүмбэр

1. **Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, цахим хаяг:**
“Хасметалл ” Захирал О.Тогоонтөмөр, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, MN-Tower, 13 давхар, 1304 тоот, улсын бүртгэлийн дугаар 9011511015, регисрийн дугаар 5887917
Утас: 7755-1819, 8802-1017

2. **Төслийн нэр, байршил:**
Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт байрлах “Өлзийт” нэртэй хайлуур жоншны орд Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт хамрагдана.

3. **Хаягдал ус хаях цэгийн байршил, координат:**
Уурхайн орчинд

4. **Цэвэрлэгээний арга, түвшин:**
Унд, ахуйн хаягдал усыг орон нутгийн бохир ус татан зайлуулах компаниар татан зайлуулна.

5. **Хаягдал усны хэмжээ:**
Тус компанийн хаягдал усны хэмжээг Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2024 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн №28 дугаартай ус ашиглуулах дүгнэлтээр гаргасан унд, ахуйн хэрэглээнд ашиглах 420.0 $м^3$/жил-ийг үндэслэн тооцов.

6. **Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ, төрөл:**
Хаягдал усны шинжилгээ хийлгүүлээгүй тул Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын`хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн “Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг тогтоох тухай” А/816/218 тушаалаар батлагдсан хэмжээг үндэслэн ахуйд ажилчдын тосгон 1.5кг/$м^3$-ээр тооцов.

7. **Ус бохирдуулсны төлбөр, тооцоо:**
Органик бодис /XXX/ 1.5кг/$м^3$ x 420.0 $м^3$/жил x 50төг/кг = **31’500 төгрөг** /гучин нэгэн мянга таван зуун төгрөг/

8. **Хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартын талаар зөвлөмж:**
- Байгаль орчин, ногоон хөгжлийн Сайдын 2013 оны А/156 дугаар тушаалаар баталсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын 2.1.4, 3.6.1 дэх заалтын дагуу хаягдал усны шугам дээр тоолуур суурилуулах
- “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартаас давсан бол “Усны тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, БОАЖ-ын Сайдын 2019 оны А/635 дугаар тушаалаар баталсан “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ын дагуу нөхөн төлбөр ногдуулахыг анхаарах.

9. **Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ:**
- “Усны тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.13 дахь заалтад заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргатай байгуулсан “Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ”-г дүгнүүлж, сунгуулах
- “Усны тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтад заасны дагуу Дорноговь аймгийн Даланжаргалан сумаас олгосон “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичиг”-ийг сунгуулах;
- Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах бөгөөд улирал бүр хоёроос доошгүй хаягдал усны сорьц авч, итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн, сүүлийн сарын 15-ны дотор ирүүлэх;
- Хаягдал ус хаях цэгийн байршлыг тогтоолгож Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГ-аас зөвшөөрөл авах
- Ус бохирдуулсны төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлөх ба хугацаанд нь төлөөгүй тохиолдолд “Зөрчлийн тухай” хуулиар хариуцлага хүлээх нөхцөл үүсэхийг анхаарах;
- Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус бохирдуулсны төлбөрийн гэрээг дүгнэсэн акт, хаягдал усны шинжилгээний дүгнэлтүүд, төлбөр төлсөн баримтыг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны Umardgobi14@gmail.com цахим хаягаар 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**ХЯНАСАН:**
УГТ - ХДТСГЗАХИРГААНЫ ДАРГА Б. ОТГОНСҮРЭН

**БОЛОВСРУУЛСАН:**
УГТ - ХДТСГЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.САРАНТУЯА

*Зураг 15. Хаягдал усны дүгнэлт*



МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 3241200094156

| | |
|---|---|
| ГТД / Регистр: | 84101479112 / 5887917 |
| Татвар төлөгчийн нэр: | Хас металл |
| Татварын төрөл: | 01030724 - Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр |
| Харъяалах татварын алба: | Дорноговь / Даланжаргалан |
| Төлсөн дүн: | 2,262,624.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-12-02 18:44:44.0 |
| Гүйлгээний утга: | [3241200094156; 84101479112; 5887917; null; Хас металл; 00000000; 5219095592; ХАС МЕТАЛЛ];5000 99999;00000000 |
| Татварын данс: | До.Ус ашигласны төлбөр - 100060000944 |
| Төлөлтийн хэлбэр: | ХААН банк |

*Зураг 16. Ус ашигласны төлбөр төлсөн баримт*

### *1.2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт*

Даланжаргалан сумын Засаг даргатай байгуулсан хог хаягдлын гэрээний дагуу сумын нэгдсэн хогийн цэгт зайлуулав. Хог хаягдлын гэрээг зураг 20-т оруулав.

## 2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус онд уурхайн олборлолтын үйл ажиллагаа тухайн оны уулын ажлын төлөвлөгөөний дагуу ашиглалтын талбайд нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй байна.

# 3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 4. Дүйцүүлэн хамгааллын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээ*

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хамгаалах арга хэмжээ | Зардал /төг/ | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|
| **2** | Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд | Уурхайн тосгоны урд хашаалсан талбайд мод тариалах | 3 000 000 | Уурхайн тосгоны урд хашаалсан талбайд 200 ширхэг суулгацын тариалалтын ажлыг хийж гүйцэтгээд байна |
| **Нийт** | | | **3 000 000** | |

## *3.1. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажил*

“Хас Металл” ХХК нь тус онд уурхайн тосгоны урд хашаалсан талбайд хавар 100 ширхэг, намрын улиралд 100 ширхэг нийт 200 ширхэг улиасны суулгацыг тариалж, усалгаа арчилгааг тогтмол хийсэн.





*Зураг 17. Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд төслийн талбайд тариалсан мод /5 сард/*









*Зураг 18. Мод суулгах ажлыг гүйцэтгэж буй байдал /10 сарын 20-нд/*

# 4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

# 5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Өлзийт-Ухаа” төмрийн хүдрийн орд төслийн барилга, байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүргийг хүлээн ажиллана.

# 6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Зардал /төг/ | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Галын аюул | Агуулахын байгууламжийг анхан шатны галын аюулын эсрэг хэрэгслээр холбогдох норм, дүрэм журмыг баримтлан хангах (галын хор, элс, ус нөөцлөх сав гэх мэт) галын аюулын эсрэг хэрэглэх материалыг шинэчлэн солих (галын хорын ашиглах хугацаанаас хамаарч, анхааруулах самбар, гал гарах үед хэрэглэх багаж хэрэгсэл..,) | 350 000 | Оффисийн барилга дотор галын аюулгүй ажиллагааны самбар, галын хор байршуулсан. /Зураг 20/ |
| | | Төслийн талбайд болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гал унтраах хэрэгслийн хугацаа, ажиллагаанд хяналт тавьж шалгах | | Оффист байршуулав. |
| 2 | Гамшиг, осол аюул | Гамшиг, ослын байдлыг хязгаарлах төлөвлөгөөг ажилчдад таниулж сургах ба сургалтын протокол хөтөлж баримтжуулах | - | Аюулгүй ажиллагааны дэвтэр хөтлөн үйл ажиллагаа явуулдаг. |
| | | Ажилчдыг галын хор болон бусад хэрэгслийг ашиглаж сургах, дадлага эзэмшүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авах | Үйл ажиллагааны зардлаар | Даланжаргалан сумын төвд зохион байгуулагдсан аюулгүй ажиллагааны сургалтанд уурхайн 2 ажилтан хамрагдаж, үнэмлэхтэй болсон. |
| **Нийт зардал** | | | 350 000 | |











*Зураг 19. Галын аюулгүй байдлыг хангах самбар, галын аюулгүй байдлын хэрэгслүүд*

# 7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт*

| Хог хаягдлын ангилал | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Зардал | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|---|
| **Ахуйн хог хаягдал** | Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг Даланжаргалан сумын Засаг даргатай байгуулж сумын нэгдсэн хогийн цэгт тогтмол зөөвөрлөн зайлуулах | Үйл ажиллагааны зардлаар | Даланжаргалан сумын засаг даргатай 2024.03.19-ны өдөр байгуулсан гэрээний дагуу хог хаягдлын сумын хаягдлын цэгт тээвэрлэн зайлуулж байна. |
| | Хог хаядлын төлбөрөө төлөх | | Гэрээний дагуу хог хаягдлын төлбөрийг төлсөн. /Зураг 21/ |
| **Нийт** | | - | |



Батлав:
“Хас метал”
захирал: ……………………Ю.Тогоонтөмөр /
2024 оны 03 сарын 19 өдөр

Батлав:
Даланжаргалан сумын Засаг
дарга: ……………………Д.Бэхбат
2024 оны 03 сарын 19 өдөр

**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**

2024 оны 03 сарын 19-ны өдөр №

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 9.2, 20.1, 20.2, Сумын ИТХ-ийн 2022 оны 12 сарын 12 өдрийн 11/07 тоот тогтоолыг үндэслэв.

Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

**Хоёр.Гэрээ байгуулагч талууд**

Нэг талаас Дорноговь аймгийн Даланжаргалан сумын ЗДТГ-ыг төлөөлж БОБМэргэжилтэн ажилтай С.Дандарбаатар нөгөө талаас “Хас метал” ХХК-ийн /Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг 5-р хороо МН таувор 1304 тоот улсын бүртгэлийн 5887917тоот регистерийн дугаартай Хасметалл ХХК-ийн Геологич Н.Дамдинжав нар харилцан тохиролцож 2024 оны 01 сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 сарын 31-ийг хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

**Гурав.Төлбөр тооцсон байдал:**

Далажаргалан сумын ИТХ-ийн 2022 оны 11/07 тоот тогтоолын 1-р хавсралтад заасан: 1 сарын төлбөр 70,000 төгрөг, 11-30 хүртэлх хүнтэй АМ-н тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН гэсэн залтыг үндэслэн сарын 70,000/-өөр тооцож

Ажилах хугацаа: 12 сар ……………………
Сарын төлбөр: 70,000……………………төг
Жилийн нийт төлбөр: 840,000……………………төг



**Дөрөв. Сумын ЗДТГ эрх**

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хог хаягдлын хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасаны төлбөрийг төвлөрүүлэх
3. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэнд хяналт тавих

**Тав. Иргэн, ААН байгууллагын эрх үүрэг**

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн, хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх
2. Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө улирал бүрийн сүүл сарын 15 ний дотор гэрээнд заасцаар Даланжаргалан сумын ЗДТГ-ын татварын байцагчаар нэхэмжлэх үүсгүүлэн 24 цагийн дотор тогтмол шилжүүлж байна.
3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаархи дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг сумын захиргаанд мэдээлж байх
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлж, сургалт сурталчилгаа явуулах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох;
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах;
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх

**Зургаа.Гэрээний хариуцлага**

6.1.Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог



хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохиролыг арилгах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

6.2.Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Даланжаргалан сумын ЗДТГ-н
БОБМэргэжилтэн
……………………/С.Дандарбаатар/
Утас:95018801

“Хас металл”ХХК -н
Геологич
……………………/Н.Дамдинжав /
утас: 88021017

*Зураг 20.Орон нутагтай байгуулсан хогны гэрээ*



**Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information**

Журналын/Journal No: 22992808

Системийн огноо/System Date: 2024.11.27 14:08:45

| Дт/ From | IBAN/Дансны/ Картын дугаар IBAN/Account/Card number | Нэр/Name | Дүн/Amount | Ханш/Rate |
|---|---|---|---|---|
| | 5219095592 | ХАС МЕТАЛЛ | 840,000.00 MNT | 1.00 |
| / Найман зуун дөчин мянган төгрөг / | | | | |
| Кт/ To | Банкны дугаар/Branch No | Банкны нэр/Bank Name | | |
| | 05 | Khan Bank - Хаан банк | 840,000.00 MNT | 1.00 |
| | IBAN/Дансны/ Картын дугаар IBAN/Account/Card Number | Нэр/Name | | |
| | 5176120446 | МТА.ТАТВАР | | |

Гүйлгээний утга/Transaction description:
2241102265418; 5887917; 00000000

**Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers**

*Зураг 21. Хогны төлбөр төлсөн баримт*

# 8. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

*Хүснэгт 7. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт*

| Хэрэгжүүлэх арга хэмжээ | Зардал /төг/ | Арга хэмжээний биелэлт |
|---|---|---|
| Байгууллагын дээд удирдлагын зүгээс тогтмол хугацаанд хийх хяналт шалгалтын үйл ажиллагаа, байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийн үзүүлэлт, үр дүнг танилцуулах | - | Үйл ажилллагаанд хэрэгжүүлэн ажиллав. |
| Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл уурхай ажлаа зогсоож энэ тухай дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх | - | Төслийн үйл ажиллагааны турш түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй |
| Төслийн зүгээс байгаль орчин, нийгэм эдийн засгийн зохистой үзүүлэлтийг хангах, төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх | - | Үйл ажилллагаанд хэрэгжүүлэн ажиллав. |
| Орон нутгийн удирдлага, бизнес, малчид, уул уурхайн компанийн хооронд харилцан ашигтай бизнесийн харилцаанд суурилсан түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх | - | Орон нутгийн малчид, иргэдтэй хамтран ажиллаж, дэмжлэг, туслалцааг үзүүлэв. |
| Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | 9 200 000 | 2024.09 болон 10 сард “Мон газар консалтинг” ХХК-аар гүйцэтгүүлсэн |
| **Нийт** | - | |

*Хүснэгт 8. Даланжаргалан суманд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлууд*

| № | Хийсэн ажил | Зардал, төг |
|---|---|---|
| 1 | Даланжаргалан сумын орох хаалгыг хийсэн. | 36 000 000 |
| 2 | Даланжаргалан сумын малчин өрхүүдэд 500 боодол өвс өгсөн. | 7 000 000 |
| 3 | Даланжаргалан сумын малчин өрхүүдэд 50 шуудай буюу нийт 2 тн тэжээл өгсөн. | 2 000 000 |
| 4 | Нөлөөллийн бүсийн малчдын өвөлжөөний бууцыг түрж өгсөн. | Өөрийн техникээр |
| **Нийт** | | **45 000 000** |



"МОН ГАЗАР КОНСАЛТИНГ" ХХК

"ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС" ХХК-ИЙН "САЛХИТЫН МӨНГӨ-АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ" ТӨСӨЛД ХИЙСЭН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН НИЙЦЭЛ, ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН НЭГДСЭН ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ

Байгаль орчны аудит хийсэн мэргэжлийн байгууллага:
"Мон Газар Консалтинг" ХХК-ийн захирал, ахлах аудитор Ю.Дэлгэрмаа

Аудиторууд: Ч.Сономдагва
Г.Болдбаяр
Б.Даваажаргал

Туслах аудтор: О.Сарангоо
Э.Амартайван

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

"МОН ГАЗАР КОНСАЛТИНГ" ХХК

"ХАС МЕТАЛЛ" ХХК-ИЙН "ӨЛЗИЙТ-УХАА ТӨМРИЙН ХҮДРИЙН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ" ТӨСӨЛД ХИЙСЭН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН НИЙЦЭЛ, ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

*Зураг 22. Байгаль орчны аудит хийлгэж баталгаажуулсан нүүр*

Даланжаргалан сумын орох хаалгыг сумын иргэн Цэрэнпүрэвтэй 36 саяын гэрээг байгуулан "Хас металл" ХХК-ийн өөрийн хөрөнгөөр гүйцэтгүүлсэн.




*Зураг 23. Даланжаргалан сумын орох хаалгыг гүйцэтгэсэн байдал*



Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавсралт

eBARIMT.MN

ТӨЛБӨРИЙН БАРИМТ

ДДТД: 073592072317000240629000001478264
Борлуулагчийн:
ТТД: ЕЮ92072317
НЭР: ЦЭВЭГСҮРЭН
Хаяг: Монгол, Говьсүмбэр, Сүмбэр, 1-р баг, хээнций 2,
Утас: 99939971
Банкны нэр: ......
Банкны дансны дугаар: ......

Огноо: 2024-06-29
Худалдан авагчийн:
ТТД: 5887917
Нэр: Хас металл
Хаяг: Монгол, Улаанбаатар, Чингэлтэй, 5-р хороо, самбуугийн гудамж, Эм Эн тауэр 1304 тоот
Утас: 70111819, 88011112

| Д/Д | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Код | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Бүгд үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | гэрэлт хаалга ажлын төлбөр | 5457000 | ш | 1 | 36,000,000 | 36,000,000 |

| | |
|---|---|
| Бараа, ажил үйлчилгээний үнэ: | 36,000,000 |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар: | 0 |
| Нийслэл хотын албан татвар: | 0 |
| Нийт дүн: | 36,000,000 |

Хүлээн авсан: ........................................ /................................/
(гарын үсэг) (нэр)
Хүлээлгэн өгсөн: ........................................ /................................/
(гарын үсэг) (нэр)

*Зураг 24. Даланжаргалан сумын орох хаалгыг гүйцэтгэсэн ажлын төлбөрийн баримт*




*Зураг 25. Малчдад 500 боодол өвс хүлээлгэн өгөхөөр бэлдэж буй байдал*




*Зураг 26. Малчдад 2 тн тэжээл хүлээлгэн өгөхөөр бэлдэж буй байдал*



*Зураг 27. Нөлөөллийн бүсийн айл өрхийн малчдын бууцыг түрж буй байдал*

# ДҮГНЭЛТ

“Хас металл” ХХК нь Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт MV-021469 дугаар ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Өлзийт-Ухаа төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах” төслийн олборлолтын үйл ажиллагааг 4 дүгээр сарын 01-нээс 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 3 сарын хугацаанд үйл ажиллагаа явуулсан.

2024 оны Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд 9,994,000 төгрөгийг төсөвлөн батлуулсан бөгөөд 19,800,000 төгрөгийг сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалал, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зарцуулан ажилласан байна.